



**ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 65

Чингис хот

Нөөцийн сангаас нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.8, 2.3, 2.3.5, 2009 оны 99 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.1, 6.2, 6.2.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2016 оны 54 дүгээр тогтоолоор төрийн жинхэнэ албан тушаалтны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Даваабошго овогтой Сарангэрэлийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хууль эрх зүйн асуудал хариуцсан ажилтны сул ажлын байранд санал болгосугай.

2. Энэхүү тогтоолыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /С.Бат-Эрдэнэ/-д хүргүүлэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ч.Болормаа/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР